

**“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2015 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын нэр:	Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурал		
Огноо:	2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 11:00-13:00	Уулзалтын газар:	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ийн хурлын заал
Хурлын дарга:	Т.Батмагнай, МЦХ ХК-ийн гүйцэтгэх захирал		
Гооллогын комиссо:	А.Цэндсүрэн, Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн Ш.Нямсүрэн, Бизнес хөгжил, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Т.Баярцогт, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн		
Хурал зохион байгуулах комиссо:	Б.Ганбат, Стратеги төлөвлөлт, маркетингийн газрын дарга Н.Амарбаясгалан, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Азбаяр, Эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн		
Оролцсон хувьцаа эзэмшигчид	Д.Эрэвгийлхам	ТӨХ, Төрийн өмчийн төлөөлөл	14,143,604 ширхэг (54.67%)
	Жү Хонг Сик	КТ корпорацийн төлөөлөл	10,348,110 ширхэг (40%)
	Б.Тунгалаг	Хувьцааны тоо	420 ширхэг (0.00162%)
	Ч.Жамбал	Хувьцааны тоо	210 ширхэг (0.00081%)
	Ч.Алимаа	Хувьцааны тоо	70 ширхэг (0.00027%)
	З.Энх-Амгалан	Хувьцааны тоо	622 ширхэг (0.00240%)
	Г.Алтанцэцэг	Хувьцааны тоо	50 ширхэг (0.00019%)
	Х.Балсандорж	Хувьцааны тоо	350 ширхэг (0.00135%)
	Д.Янжмаа	Хувьцааны тоо	30 ширхэг (0.00012%)
	Б.Нэргүй	Хувьцааны тоо	70 ширхэг (0.00027%)
	Д.Сумъяа	Хувьцааны тоо	350 ширхэг (0.00135%)
	Г.Батнасан	Хувьцааны тоо	15 ширхэг (0.00006%)
	Т.Алтан-Оч	Хувьцааны тоо	100 ширхэг (0.00039%)
Ж.Лхагвасүрэн	Хувьцааны тоо	500 ширхэг (0.00193%)	
Ирц:	94.68%		

Нийт хувьцааны тоо 2,787 ширхэг (0.01077%)

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны тайлан
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн болон хараат гишүүдийг сонгох
5. ТУЗ-ийн 2015 оны зардлын төсвийг батлах
6. 2014 оны ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Т.Батмагнай, Гүйцэтгэх захирал: Хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн амгаланг айлтгая, 2015 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээснийг мэдэгдье.

Х.Балсандорж, хувьцаа эзэмшигч: Компанийн гүйцэтгэх захирал хувьцаа эзэмшигчдийн хурлаар өнгөрсөн оны тайланг илтгэхийн зэрэгцээ хурлыг даргалах нь зохимжгүй гэж үзэж байна. Тус хурлыг ТУЗ-ийн гишүүн буюу компанийн томоохон хувьцаа эзэмшигч даргалах нь зүйтэй гэж үзэж байна.

Т.Батмагнай: ТУЗ-ийн 127 дугаар хурлаар ХЭХ-ыг удирдан даргалах үүргийг компанийн гүйцэтгэх захиралд өгсөн бөгөөд хуулиараа хурлын дэг, асуудалд өөрчлөлт оруулж болохгүй. Хувьцаа эзэмшигчдийн саналыг харгалзан тус хурлыг Төрийн өмчийн төлөөлөл Д.Эрэвгийлхамаар хөтлүүлье.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийн талаар ЗУГазрын дарга Ж. Буяндалай танилцуулав.

Х.Балсандорж, хувьцаа эзэмшигч: ТУЗ-ийн дүгнэлтийг чухал гэж үзэж байна.

Д.Эрвгийлхам, Төрийн өмчийн төлөөлөл: Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн 2014 оны үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэсэн.

2. Компанийн 2014 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн талаар СХОГ-ын дарга Ө.Сэр-Од танилцуулав.

Б.Тунгалаг, хувьцаа эзэмшигч: Элэгдлээрээ өртгөө нөхсөн буюу үлдэгдэл өртөг “0” утгатай болсон боловч данснаас хасаагүй байгаа 42 орчим тэрбум төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг дахин үнэлээгүй шалтгааныг тодруулж өгнө үү?

Ө.Сэр-Од, СХОГ-ын дарга: Элэгдлээрээ өртгөө нөхсөн ашиглалтаас гарсан зарим тоног төхөөрөмжүүдийг актлах шаардлагатай. Харин ашиглагдаж буй зарим тоног төхөөрөмж нь үйлдвэрлэгдэхээ больсон тул эдгээрийг мэргэжлийн үнэлгээний байгууллагаар үнэлүүлэхэд хүнд байдаг.

Б. Тунгалаг, хувьцаа эзэмшигч: Эдгээр хөрөнгүүдийг дахин үнэлэх боломжтой гэж үзэж байна. Учир нь миний бие бусад байгууллагын хөрөнгийг дахин үнэлэх үнэлгээний багт орон үнэлж байсан.

Т.Батмагнай, Гүйцэтгэх захирал: СХОГ-ын дарга, Ө.Сэр-Одыг хурлын дараа хувьцаа эзэмшигч Ү. Тунгалагтай хурлын дараа биечлэн уулзаж үндсэн хөрөнгө дахин үнэлэх талаар саналаа солилцохыг зөвлөж байна.

3. Компанийн Аудитын дэд хорооны тайланг Аудитын хорооны дарга А. Гэрэлд-Одын оронд СТМГ-ын дарга Б.Ганбат танилцуулав.

Б.Ганбат, СТМГ-ын дарга: Аудитын дэд хороо нь МЦХ хувьцаат компанийн санхүүгийн тайлангийн тогтвортой, найдвартай байдлыг сайшааж, мөн элэгдлээрээ өртгөө нөхсөн буюу үлдэгдэл өртөг “0” утгатай болсон боловч данснаас хасаагүй байгаа 42 орчим тэрбум төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг ТУЗ-өөр шийдвэрлүүлэхийг зөвлөмж өгсөн.

4. ТУЗ-ийн 2015 оны зардлын төсвийг батлах тухай асуудлаар СТМГ-ын дарга Б.Ганбат танилцуулав.


Б.Ганбат, СТМГ-ын дарга: Нэг зүйлийг тодруулахад ТУЗ-ийн хурлыг жилд биеэр нэг удаа БНСУ буюу Монгол Улсад зохион байгуулахаар төсөвлөдөг боловч энэхүү төсвийг хэрэглэдэггүй, харин ТУЗ-ийн хурлыг телеконференц хэлбэрээр зохион байгуулдаг.


5. 2014 оны ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаар Төрийн өмчийн төлөөлөл Д. Эрвгийлхам танилцуулав.

Д.Эрвгийлхам, Төрийн өмчийн төлөөлөл: ТУЗ нь 2015 оны 2 дугаар сарын 18-ний өдрийн 125 дугаар хурлаар 2014 оны цэвэр ашгийн 30 хувийг хуваарилах шийдвэр гаргасан.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг 100 хувийн саналаар батлав.
 - Монголын цахилгаан холбоо Хувьцаат компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав.
2. Компанийн санхүүгийн тайлангийн дүнг 100 хувийн саналаар батлав.
 - Монголын цахилгаан холбоо Хувьцаат компанийн 2014 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар батлав:
 - Нийт хөрөнгийг 40,583,242,013 (дөчин тэрбум таван зуун наян гурван сая хоёр зуун хоёр зуун дөчин мянга арван гурав) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 19,830,473,248 (арван есөн тэрбум найман зуун гучин сая дөрвөн зуун далан гурван мянга хоёр зуун дөчин найм) төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 20,752,768,764 (хорин тэрбум долоон зуун тавин хоёр сая долоон зуун жаран найман мянга долоон зуун жаран дөрөв) төгрөгөөр
 - Өр төлбөрийн нийт дүнг 8,249,064,791 (найман тэрбум хоёр зуун дөчин есөн сая жаран дөрвөн мянга долоон зуун ерэн нэг) төгрөгөөр
 - Эзэмшигчийн өмчийг 32,334,177,221 (гучин хоёр тэрбум гурван зуун гучин дөрвөн сая нэг зуун далан долоон мянга хоёр зуун хорин нэг) төгрөгөөр
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны тайланг 100 хувийн саналаар батлав.
 - Монголын цахилгаан холбоо Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос компанийн 2014 оны санхүүгийн тайланд өгсөн 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн дүгнэлтийг батлав.
 - Монголын цахилгаан холбоо Хувьцаат Компани болон Мэдээлэл холбооны сүлжээ Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хооронд үүссэн тооцооны зөрүүг Харилцаа холбооны зохицуулах хороо, Төрийн өмчийн хороонд тавьж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Т.Бат-Магнай)-д даалгав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 100 хувийн саналаар батлав.
 - Монголын цахилгаан холбоо Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Ж. Ганбат, Ж. Үнэнбат, Мүүн Жүнг Ёонг, хараат бус гишүүнээр Кан Ён Мин нарыг батлав.
 - Компанийн өмнө тавигдсан зорилтыг ханган биелүүлэхэд Гүйцэтгэх удирдлагад дэмжлэг үзүүлж ажиллахыг гишүүдэд үүрэг болгов.
5. ТУЗ-ийн 2015 оны зардлын төсвийг 100 хувийн саналаар батлав.
 - Монголын цахилгаан холбоо Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны зардлын төсвийг хавсралт ёсоор батлав.
 - Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй байхын хамт гишүүдийн цалин хөлсийг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.

Боловсруулсан:  Н.Амарбаясгалан, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Танилцсан:  Т.Батмагнай, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал